



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай**


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 05/6978 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Авто зам, засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Гадаад хамтын ажиллагааны албаны дарга Д.Энхбаярыг томилсугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ